

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 2024 ОНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: БУА-2025/06-04-ШТА-НА

БУЛГАН АЙМАГ
2025

Булган дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудиторын албан тушаалын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч Ж.Энхцоодол
Утас: 7034-2716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Ахлах аудитор: Г.Намчинсүрэн
Утас: 7034-2495 Цахим хаяг: Namchinsureng@audit.gov.mn
Аудитор: А.Сувдаа
Утас: 7034-2716 Цахим хаяг: Suwdaaa@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу. bulgan@audit.gov.mn

Агуулга

Товчилсон үгийн тайлбар.....	2
Хүснэгтийн товъёг	2
Ерөнхий мэдээлэл:.....	3
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ.....	4
1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл арга хэмжээг төлөвлөөгүй байна.....	5
1.1 Булган аймагт шинээр хэрэгжүүлэх 29 төсөл, арга хэмжээний 41.3 хувь нь “Монгол улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-тэй, 68.3 нь “Монгол улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-тэй нийцээгүй байна. ..	5
1.2 Хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээг аргачлалын дагуу үнэлж эрэмбэлэн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцож төлөвлөөгүй байна.	5
1.3 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хуульд заасан техник, эдийн засгийн үндэслэл, батлагдсан зураг төсвийн шаардлага хангагдаагүй арга хэмжээг тусгасан байна.....	6
1.4 Тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгө оруулалтын арга хэмжээг төлөвлөсөн ч зарим төсөл арга хэмжээ Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцээгүй байна.	7
2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.....	7
2.1 Эрх шилжин ирсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 62.5 хувийг нээлттэй тендер шалгаруулалтаар, 37.5 хувийг харьцуулалтын аргаар зохион байгуулсан байна.....	7
2.2 Зарим хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийн техникийн тодорхойлолт холбогдох хуулийн заалттай нийцээгүй байна.	9
2.3 Холбогдох хууль, журам, тендерийн баримт бичигт тусгасан шаардлагыг хангасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.....	10
3. Эрх шилжиж ирсэн бүрэн хэрэгжсэн хөрөнгө оруулалтын хоёр төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд нь гүйцэтгүүлэн байнгын ашиглагч байгууллага бүртгэлд тусгасан байна.....	10
3.1 Эрх шилжин ирсэн төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэлд санхүүжилт олгохдоо журамд заасан баримт бичгийн бүрдлийг бүрэн бүрдүүлээгүй байна.	10
3.2 Хэрэгжсэн зарим төсөл, арга хэмжээнд санхүүжилтийг бүрэн олгосон ч журамд заасны дагуу гэрээг дүгнээгүй, үүрэг даалгаврын биелэлтийг цаасаар баримтжуулаагүй байна.	11
3.3 Эрх шилжиж бүрэн хэрэгжсэн зарим хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг техникийн тодорхойлолтын дагуу хүлээж аваагүй байна	11

3.4 Эрх шилжиж ирэн хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг байнгын ашиглагч байгууллага бүртгэлд тусгасан байна.

.....	12
ДҮГНЭЛТ:	13
ЗӨВЛӨМЖ:	14

Товчилсон үгийн тайлбар

БОУАӨС	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд
БЦГ	Байгалийн цогцолборт газар
ГНАГ	Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗТС	Зам тээврийн сайд
НА	Нийцлийн аудит
ССАЖЗС	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТБОНӨААН	Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж
ТБОНӨХБА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах
ҮХА	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЕЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТТЗ	Техник, эдийн засгийн үнэлгээ
ТЭЗҮ	Үндэсний аудитын газар
ҮАГ	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд
ХББОСС	Хүнс хөдөө аж ахуйн газар
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн сайд
ХХААХҮС	Шууд тайлагнах аудит
ШТА	Эрүүл мэндийн газар
ЭМГ	

Хүснэгтийн товъёг

Хүснэгт 1: Төсөл арга хэмжээний ангилал.....	3
Хүснэгт 2: УТХО-аар хэрэгжүүлэх Булган аймагт эрх шилжүүлсэн ТАХ-ний тоо, төсөвт өртгийн мэдээлэл.....	8
Хүснэгт 3: Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны судалгаа	8
Хүснэгт 4: Эрх шилжиж ирсэн төсөл арга хэмжээ /ТЕЗ-аар/	10
Хүснэгт 5: Соёлын төвийн зарим тоног төхөөрөмж.....	12

Ерөнхий мэдээлэл:

Монгол Улсын Төсвийн тухай хуульд Булган аймагт 2024 онд он дамжин хэрэгжиж байгаа 16, шинээр хэрэгжих 29 нийт 150,682.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл арга хэмжээг 67,492.6 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Хүснэгт 1: Төсөл арга хэмжээний ангидал

Ангилал	Шинэ ТАХ			Шилжих ТАХ			Нийт ТАХ		
	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Барилга байгууламж	22	69,065.2	27,799.20	16	77,140.1	35,716.4	38	146,205.3	63,515.6
Их засвар	1	424.0	424.0				1	424.0	424.0
Тоног төхөөрөмж	6	4,053.0	3553.0				6	4,053.0	3,553.0
Нийт дүн	29	73,542.2	31,776.2	16	77,140.1	35,716.4	45	150,682.3	67,492.6

Эх сурвалж : УАГ-аас ирүүлсэн судалгаанаас

Нийт санхүүжилтийн 75.4 хувийг барилга, байгууламж, 18.3 хувийг тоног төхөөрөмж, 4.1 хувийг их засварын төсөл, арга хэмжээнд тус тус зарцуулахаар төлөвлөжээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 29 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 48.2 хувь буюу 14 төсөл, арга хэмжээг 2024 онд, 51.8 хувь буюу 15 төсөл, арга хэмжээг дараагийн онуудад үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба Булган аймагт эрх шилжсэн 9 төсөл арга хэмжээ байна.

Аудитад төлөвлөлтийг Булган аймагт хэрэгжсэн нийт төсөл хөтөлбөрөөр, өмч ашиглалт, бүртгэлтэй холбоотой асуудлыг бүрэн, худалдан авалт, санхүүжилт, захиалагчийн хяналттай холбоотой асуудлыг эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний хүрээнд хийлээ.

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйлийг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоолд тусгасны дагуу “Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт”-д Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар нийцлийн аудит хийлээ.
Аудитын зорилт	Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд: - Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн эсэх; - Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэх; - Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд нь гүйцэтгүүлэн бүртгэлд тусгасан эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Аудитыг Булган аймагт 2024 онд улс, орон төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээний төлөвлөлт, төсвийн ерөнхийлөн захирагчид эрх шилжин хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын 9 төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт болон эдгээр төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагууд, төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч нарын холбогдох үйл ажиллагааг хамруулав. Аудитын явцад объектыг түүвэрлэн барилга байгууламжийн ажлын бодит гүйцэтгэлийг газар дээр нь шалгасан.
Аудитын арга зүй,	Аудитыг АДБОУС 4000-4200, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэн хянах зэрэг судалгааны арга зүйг ашиглан гүйцэтгэлээ.
Аудитын шалгуур үзүүлэлт	Аудитыг Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах нотлох баримтыг цуглуулж, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэн хянах зэрэг судалгааны арга зүйг ашиглан дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Энхцоодол хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг хийж, ахлах аудитор Г.Намчинсүрэн, аудитор А.Сувдаа нар хийж гүйцэтгэлээ. Аудитын удирдамжийн дагуу гүйцэтгэлийн аудитыг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 04 дүгээр сарын 21-ны өдөр хүртэл ажлын 15 хоногт хийж аудитыг үе шатны хяналтаар хянуулж аудитын тайланг хавсралт судалгааны хамт 2024 оны 04 дүгээр сарын 22-ний өдөр УАГ-ын ГНАГ-т, аймгийн Засаг даргад тус тус хүргүүлэн ажилласан болно.
Хүндрэл бэрхшээл	Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн бодит байдал, барилга угсралтын ажлын чанарт хяналт хийхэд цаг хугацааны хувьд хязгаарлагдмал /Санхүүгийн тайлангийн аудитын хугацаатай давхцах ТБОНӨААН, ТТЗ-ийн санхүүгийн тайлангийн аудит 03 дугаар сарын 25-наар дуусгавар болсон./ байсан ба зарим төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг цаасан нотлох баримтын хүрээнд хянасан.

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл арга хэмжээг төлөвлөөгүй байна.

1.1 Булган аймагт шинээр хэрэгжүүлэх 29 төсөл, арга хэмжээний 41.3 хувь нь “Монгол улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-тэй, 68.3 нь “Монгол улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-тэй нийцээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.8¹ дах заалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5, 6 дугаар зүйлүүдийн холбогдох заалтуудад хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулж төлөвлөхөөр заажээ.

Булган аймагт шинээр хэрэгжүүлэх 29 төсөл, арга хэмжээний 41.3 хувь нь “Монгол улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-тэй, 68.3 нь “Монгол улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-тэй нийцээгүй байна. Тухайлбал:

- ✚ Гадна инженерийн шугам сүлжээ /Булган, Дашинчилэн сум/
- ✚ Хүүхдийн тоглоомын талбай /Булган, Дашинчилэн, Хангал, Хутаг-Өндөр, Бугат, Баян-Агт, Булган сум/
- ✚ Соёлын төвийн барилга, 240 суудал /Булган, Бүрэгхангай сум/
- ✚ Төв номын сангийн барилга /Булган, Булган сум/
- ✚ Соёлын салбарын тоног төхөөрөмж /Булган/
- ✚ Соёлын төвийн тоног төхөөрөмж /Булган, Бугат сум/
- ✚ Соёлын төвийн тоног төхөөрөмж /Дашинчилэн сум/
- ✚ Прокурорын газрын барилга /Булган, Булган сум/
- ✚ Хамгаалалтын захиргааны барилгын засвар /Хөгнө Тарны БЦГ/
- ✚ Жаргалант зуслангийн өргөтгөлийн барилга, 60 ор /Булган, Бугат сум/

Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө Монгол улсын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичиг болон Булган аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлтэй ерөнхий нэршилээр уялдуулсан боловч улсын хөрөнгө оруулалтын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөтэй хангалтгүй уялдсан байна.

1.2 Хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээг аргачлалын дагуу үнэлж эрэмбэлэн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцож төлөвлөөгүй байна.

Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, төсөл арга хэмжээг үнэлж эрэмбэлэх үйл ажиллагаа журам”-ын 3.8²-д заасны дагуу 2024 онд шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг бэлтгэн төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем [/pimis.publicinvestment.gov.mn/](http://pimis.publicinvestment.gov.mn/) -д оруулж, Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Тус жагсаалтаар нийт 133,189.06 сая төгрөгийн өртөгтэй 44 төсөл арга хэмжээг хүргүүлснээс Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд барилга байгууламжийн 31, их засварын 8, тоног төхөөрөмжийн 4, ТЭЗҮ

¹ Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан байх;

² Энэхүү журам, аргачлалын дагуу Аймаг, нийслэлийн Засаг дарга нь төслийн саналыг тооцоо судалгаанд үндэслэн холбогдох аргачлалын дагуу үнэлж, эрэмбэлэн сонгосны үндсэн дээр Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ

боловсруулах 1 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба үүнээс 11 төсөл арга хэмжээг баталсан байна.

Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан 29 төсөл, арга хэмжээний 20.6 хувь нь буюу 6 нь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас санал хүргүүлээгүй, эрэмбэлж үнэлээгүй төсөл, арга хэмжээ байна. Тухайлбал:

- ✚ Хүүхдийн тоглоомын талбай /Булган, Дашинчилэн, Хангал, Хутаг-Өндөр, Бугат, Баян-Агт, Булган сум/
- ✚ Сум дундын сургуулиудын хүүхдийн зуслан /Булган, Хишиг-Өндөр сум/
- ✚ Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг /Булган, Баян-Агт/
- ✚ Прокурорын газрын барилга /Булган, Булган сум/
- ✚ Соёлын төвийн тоног төхөөрөмж /Булган, Бугат сум/
- ✚ Соёлын төвийн тоног төхөөрөмж /Дашинчилэн сум/

Орон нутгийн хэрэгцээ шаардлагад үндэслээгүй, тооцоо судалгаа хийгдээгүй, журмын шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ батлагдах нь төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулах эрсдэлтэй байна.

Мөн аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас санал хүргүүлж батлагдсан төсөл арга хэмжээнээс холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлэгдэж, эрэмбэлэгдээгүй 10, нийгэм, эдийн засгийн үр ашгийг тооцоо хийгдээгүй 2, Хөрөнгийн ашиглалттай холбоотой орон тоо, урсгал зардлын тооцоогүй 2 төсөл арга хэмжээ байгаа нь Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах” журмын 3.2.1³, 3.2.2⁴ дэх заалттай нийцэхгүй байна. /Судалгааны хүснэгт-1/

Иймд Аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагч төсөл, арга хэмжээний саналыг хүргүүлэхдээ “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, төсөл арга хэмжээг үнэлж эрэмбэлэх үйл ажиллагаа журам”-ын холбогдох заалтыг мөрдөж ажиллах шаардлагатай байна.

1.3 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хуульд заасан техник, эдийн засгийн үндэслэл, батлагдсан зураг төсвийн шаардлага хангагдаагүй арга хэмжээг тусгасан байна.

Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4⁵, 29 дүгээр зүйлийн 29.3⁶, 29.4⁷, 29/1 дүгээр зүйлийн 29/1.1, 29/1.2, Барилгын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.11⁸ дэх заалтууд, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан

³ 3.2.1.Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл нь Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалд заасны дагуу шалгуур үзүүлэлтээр үнэлэгдсэн, эдийн засгийн үр ашигтай, нийгмийн ач холбогдолтой, тэргүүлэх зэрэглэлийн төслүүд байна.

⁴ 3.2.2.Төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх дараах шаардлагыг хангаагүй төслийг төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахгүй;

⁵ Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 28.3.1-28.3.8, 28.3.12-т заасныг харгалзан улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдах 30.0 тэрбум төгрөгөөс дээш хэмжээний төсөл, арга хэмжээнд техник, эдийн засгийн үндэслэлийн урьдчилсан судалгааг хийнэ

⁶ Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны Засаг дарга, хот, тосгоны Захирагч хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт саналыг дараах байдлаар жилийн төсвийн төсөлд тусгана ...,

⁷ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана

⁸ зураг төсөлгүй барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахгүй байх;

"Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-д шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөвлөлтийн шаардлагыг тусгажээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн шинээр хэрэгжүүлэх барилга, байгууламж барих, их засвар, тохижилтын ажил хийх 5 төсөл, арга хэмжээ нь зураг, төсөвгүй, 2 жилээс дээш хугацаанд хийлгэсэн магадлалын дүгнэлттэй, зарим тоног төхөөрөмж нийлүүлэх, ТЭЗҮ боловсруулах төсөл, арга хэмжээ нь техникийн тодорхойлолтгүй 7 төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна. /Хавсралт-1, Судалгааны маягт-1/

Энэ нь хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын цар хүрээ, хийгдэх ажлын тоо хэмжээ тодорхой бусаас санхүүжилт дутагдах, үргүй зардал гаргах, тухайн төсөл арга хэмжээ хугацаандаа хийгдэхгүй байх, дахин санхүүжилт шаардлагатай болох эрсдэлтэй байгаад анхаарч холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хөрөнгө оруулалтыг төлөвлөх шаардлагатай байна.

1.4 Тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгө оруулалтын арга хэмжээг төлөвлөсөн ч зарим төсөл арга хэмжээ Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцээгүй байна.

Шинээр хэрэгжүүлэхээр эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээнээс Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.4.¹⁹-д заасан заалттай нийцээгүй 1 төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна. Үүнд:

- ✚ Хүүхдийн тоглоомын талбай /Булган, Дашинчилэн, Хангал, Хутаг-Өндөр, Бугат, Баян-Агт, Булган сум/ гэх нэршилтэй боловч хүүхэд залуусын цэцэрлэгт хүрээлэн гэсэн нэг маягын зураг төсөвтэй байна.

2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.

2.1 Эрх шилжин ирсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 62.5 хувийг нээлттэй тендер шалгаруулалтаар, 37.5 хувийг харьцуулалтын аргаар зохион байгуулсан байна.

Төсвийн тухай хуулийн 14.4¹⁰-д заасны дагуу Булган аймагт улсын төсвийн хөрөнгөөр нийт 6,289.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2024 онд 2,949.0 сая төгрөгөөр санхүүжих 9 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр эрх шилжүүлжээ.

Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.1.1-т төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхээ төсвийн төвлөрүүлэн захирагч, харьяалах төсвийн шууд захирагчид эсвэл аймаг, нийслэлийн Засаг даргад тухайн жилийн 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор шилжүүлж болно гэж заажээ. Гэвч тайлант онд эрх шилжиж ирсэн 8 ажлын 7 төсөл, арга хэмжээний эрх шилжүүлсэн шийдвэр дээрх хугацаанд багтаж гарсан бол 1 төсөл, арга хэмжээний эрх шилжүүлсэн шийдвэр 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдөр гарсан байна.

⁹ 13.4.1. орон нутгийн нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, хаягжуулалт, гэрэлтүүлэг, тохижилт;

¹⁰ 14.4.-д "Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөв хуваарилах, зарцуулахтай холбогдсон бүрэн эрхээ төсвийн төвлөрүүлэн захирагч, эсхүл харьяалах төсвийн шууд захирагчид шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй."

Булган аймгийн худалдан авах ажиллагааны газар нь ТБОНӨХБАҮХАТХ -ийн 44.4¹¹, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын 3.2-д¹² заасны дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэн баталгаажуулан цахим системд нийтэлжээ.

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 9.1¹³, 31.1¹⁴ -д заасны дагуу нээлттэй болон, харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ил тод байдлыг хангаж цахим системээр зохион байгуулсан байна.

Хүснэгт 2: УТХО-аар хэрэгжүүлэх Булган аймагт эрх шилжүүлсэн ТАХ-ний тоо, төсөвт өртгийн мэдээлэл

							/сая төгрөг/			
ТЕЗ	Төсөл арга хэмжээний ангилал	Төсөл арга хэмжээний тоо	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Худалдан авах ажиллагааны журам			
			Эхлэх	дуусах			Нээлттэй тендер шалгаруулалт		Харьцуулалтын арга	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗТС	Барилга, байгууламж	4	2024	2026	5,800.0	2,460.0	4	5,800.0		
БОУАӨС	Их засвар	4	2024	2024	424.0	424.0	1	252.0	3	172.0
ССАЖЗС	Тоног төхөөрөмж	1	2024	2024	100.0	100.0			1	100.0
Нийт дүн		9			6,324.0	2,984.0	5	6,052.0	4	272.0

Эх сурвалж : ХААГ-аас ирүүлсэн судалгаанаас

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 9.1¹⁵-д заасны дагуу нээлттэй болон, харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ил тод байдлыг хангаж цахим системээр зохион байгуулсан байна.

Аймгийн ХХААГ нь 3 сайдын багцын 6,289.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны 62.5 хувийг нээлттэй тендер шалгаруулалтаар, 37.5 хувийг харьцуулалтын аргаар зохион байгуулж 6,173.0 сая төгрөгөөр 8 гүйцэтгэгчийг сонгож 116.0 сая төгрөгийн хэмнэлт үүсгэжээ.

Хүснэгт 3: Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны судалгаа

№	ТЕЗ	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөл, арга хэмжээний ангилал	Төсөвт өртөг	Шалгарсан үнийн дүн		Тендерийн хэмнэлт
					Санхүүжих дүн	Нээлттэй тендер шалгаруулалт	
1	ЗТС	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 1.5 км /Булган, Гурванбулаг сум/	Барилга байгууламж	1,500.0	1,469.35	30.65	

¹¹ Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн жилийн санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш нэг сарын дотор харьяа захиалагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэн хянаж, баталгаажуулан цахим системд нийтэлнэ"

¹² Захиалагч тухайн жилийн төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хэвсрэлтын маягт 1-ийн дагуу боловсруулж, түүнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадал, төсөвт өртөг, худалдан авах ажиллагаанд мөрдөх журам, арга, хэрэгжүүлэх хугацаа болон холбогдох тайлбар, тодруулга зэрэг мэдээллийг тодорхой тусгана.

¹³ .Хуульд өөрөөр заагаагүй бол худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэнэ.

¹⁴ 31.1.Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийг дагуу зохион байгуулна:

¹⁵ Хуульд өөрөөр заагаагүй бол худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэнэ.

2	ЗТС	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 1.7 км /Булган, Сайхан сум/	Барилга байгууламж	1,500.0	1,499.71	0.29
3	ЗТС	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 1.7 км /Булган, Сэлэнгэ сум/	Барилга байгууламж	2,200.0	2,199.59	0.41
4	ЗТС	Сумын төвийн хатуу хучилттай авто замын эхлэл, 0.8 км /Булган, Хутаг-Өндөр сум/	Барилга байгууламж	600.0	530.4	69.61
5	БОУАӨС	Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын байгууллагуудын их засвар /Улсын хэмжээнд/- Цаг уурын өртөөний барилгын их засвар /Булган, Хутаг-Өндөр/	Их засвар	97.0	93.51	3.49
6	БОУАӨС	Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын байгууллагуудын их засвар /Улсын хэмжээнд/- Цаг уурын өртөөний хашаа, засвар /Булган, Могод/	Их засвар	40.0	39.8	0.20
7	БОУАӨС	Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын байгууллагуудын их засвар /Улсын хэмжээнд/- Цаг уурын өртөөний барилгын шинэчлэл /Булган, Сэлэнгэ, Ингэт толгой/	Их засвар	252.0	251.8	0.23
8	ССАЖЗС	Соёлын төвийн тоног төхөөрөмж /Булган, Дашинчилэн сум/	Тоног төхөөрөмж	100.0	88.88	11.12

Эх сурвалж : ХААГ-аас ирүүлсэн судалгаа, баримтаас

2.2 Зарим хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийн техникийн тодорхойлолт холбогдох хуулийн заалттай нийцээгүй байна.

Эрх шилжиж ирсэн төсөл арга хэмжээний тендерийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн боловсруулан батлуулж, тендерийг цахимаар зохион байгуулсан мөн тайлант онд хэрэгжих боломжтой байдлаар зохион байгуулсан байна.

Зарим төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолт нь ТБОНӨХБАҮХАТХ 12.4¹⁶, 12.5¹⁷-д заалттай нийцээгүй байна. Үүнд:

- Соёлын сайдын багцаас эрх шилжин ирсэн Дашинчилэн сумын Соёлын төвийн 100 сая төгрөгийн өртөгтэй төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолтод зарим тоног төхөөрөмжийн худалдааны нэрийг /JBL SRX725 өндөр хүчин чадлын хос өсгөгч, JBL SRX728 өсгөгч, Mixer YAMAHA MG16/ гэх мэтээр тодорхойлон оруулсан байна.

Иймд захиалагч техникийн тодорхойлолтыг боловсруулахдаа холбогдох хууль дүрэмд нийцэж байгаа эсэхэд хяналт хийж байх шаардлагатай байна.

Мөн ТБОНӨХБАҮХАТХ-ийн 12.9¹⁸-д техникийн тодорхойлолтыг хүрээлэн байгаа орчинд ээлтэй хэлбэрээр боловсруулах аргачлал, зааврыг байгаль орчны болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батлаагүй байна.

¹⁶ Техникийн тодорхойлолтод тодорхой нэг аж ахуй эрхлэгчийн бараа, үйлчилгээний худалдааны нэр, патент, түүнийг эзэмшигч, үйлдвэрлэгч, нийлүүлэгч, эсхүл үйлдвэрлэлийн арга, гарал үүслийг тухайлан заахыг хориглоно.

¹⁷ Техникийн тодорхойлолтыг нарийвчлан тодорхойлох боломжгүй бол энэ тухай үндэслэл бүхий тайлбарыг дурдсаны үндсэн дээр зөвхөн тухайн бараанд холбогдуулан энэ хуулийн 12.4-т заасан шаардлага, нөхцөлийг тавьж болох бөгөөд энэ тохиолдолд "эсхүл түүнтэй дүйцэх" гэсэн тодотгол хэрэглэнэ.

¹⁸ Техникийн тодорхойлолтыг хүрээлэн байгаа орчинд ээлтэй хэлбэрээр боловсруулах аргачлал, зааврыг байгаль орчны болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

2.3 Холбогдох хууль, журам, тендерийн баримт бичигт тусгасан шаардлагыг хангасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

ТБОНӨХБАҮХАТХ, Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”, 2023 оны 278 тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д нийцүүлэн тендерийн баримт бичигт тусгагдсан шаардлагыг хангасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

Төсвийн Ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчид эрх шилжүүлсэн 4 төсөл арга хэмжээнээс 3 төсөл арга хэмжээг аймгийн худалдан авах ажиллагааны газар зохион байгуулж 1 төсөл арга хэмжээ буюу Хөгнө-тарнын БЦГ-ын хамгаалалтын захиргааны барилгын их засварын ажлыг төсвийн шууд захирагч худалдан авах ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан байна.

3. Эрх шилжиж ирсэн бүрэн хэрэгжсэн хөрөнгө оруулалтын хоёр төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд нь гүйцэтгүүлэн байнгын ашиглагч байгууллага бүртгэлд тусгасан байна.

3.1 Эрх шилжин ирсэн төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэлд санхүүжилт олгохдоо журамд заасан баримт бичгийн бүрдлийг бүрэн бүрдүүлээгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд эрх шилжсэн өмнөх оноос шилжин ирсэн ХББОСС-ын хүрээний 1 төсөл, арга хэмжээний¹⁹-д 51.2 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталсан ч зураг, төсөвт өөрчлөлт орж дахин магадлал хийлгэснээс тайлант онд санхүүжилт олгогдоогүй байна.

Тайлант онд 4 ТЕЗ-ийн эрх шилжин 9 төсөл, арга хэмжээний ЗТС-ын 3, ССАЖЗС-ын багцаас 1 төсөл, арга хэмжээний эрхийг Булган аймгийн Засаг даргад шилжүүлж нийт 1,906.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Мөн БОУАӨС-ын 4 төсөл, арга хэмжээний Булган аймгийн Хөгнө Тарны БЦГ-ын хамгаалалтын захиргаанд 1, сайдын багцаас Ус, цаг уур, орчны шинжилгээний төвд 3 төсөл, арга хэмжээний эрхийг шилжүүлж санхүүжилтийг яамнаас олгожээ.

Хүснэгт 4: Эрх шилжиж ирсэн төсөл арга хэмжээ /ТЕЗ-аар/

ТЕЗ	ТАХ тоо	Төсөвт өртөг /анхны/	Төсөвт өртөг /2024 оны/	Батлагдсан санхүүжилт	Санхүүжих дүн /өөрчлөлт оруулсан/	Санхүүжүүлсэн дүн	Үлдэгдэл санхүүжилт
ХББОСС	1	165.0	163.5	51.2	51.2	-	51.2
Шилжиж ирсэн	1	165.0	163.5	51.2	51.2	-	51.2
ССАЖЗС	1	-	100.0	100.0	100.0	88.8	11.2
ЗТС	4	-	5,800.0	2,460.0	2,460.0	1,817.3	642.7
БОУАӨС ²⁰	4	-	-	-	-	-	-
Шинээр хийгдсэн	9	-	5,900.0	2,560.0	2,560.0	1,906.1	653.9

Эх сурвалж : УАГ-аас ирүүлсэн судалгаанаас

Дээрх төсөл, арга хэмжээнд санхүүжилт олгохдоо ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.3-т заасантай нийцээгүй байна. Тухайлбал:

¹⁹ Халуун усны барилга /Булган, Могоод сум/, 2022-2024 онд хэрэгжих,

²⁰ Санхүүжилтийг яамнаас олгосон

- ✚ Сумын төвийн хатуу хучилттай авто замын гүйцэтгэлд санхүүжилт хүссэн албан бичиг,
- ✚ Үнэлгээний хороо байгуулсан шийдвэр, үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл,
- ✚ Захиалагчийн хянан баталгаажуулсан ил далд ажлын акт, ажлын гүйцэтгэлийг нотолсон гэрэл зураг,
- ✚ Байнгын ашиглалтад хүлээн авах комиссын хурлын тэмдэглэл, үүрэг даалгаврын биелэлт,
- ✚ Байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт зэрэг төсөл, арга хэмжээний санхүүжилт олгох баримт бичгийн бүрдэл дутуу байна.

ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.3.12.1²¹-д заасны дагуу Зам тээврийн яамны дансанд 5.9 сая төгрөгийг төвлөрүүлэлгүй гүйцэтгэгчдэд олгосон байна.

3.2 Хэрэгжсэн зарим төсөл, арга хэмжээнд санхүүжилтийг бүрэн олгосон ч журамд заасны дагуу гэрээг дүгнээгүй, үүрэг даалгаврын биелэлтийг цаасаар баримтжуулаагүй байна.

Дээр дурдсан эрх шилжсэн 5 төсөл, арга хэмжээний сумын төвийн хатуу хучилттай авто замын 3 төсөл, арга хэмжээ дараа онд шилжсэн бөгөөд 2 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжжээ.

ССАЖЗС-ын багцаас эрх шилжүүлсэн соёлын төвийн тоног төхөөрөмжийг гүйцэтгэгч хугацаандаа нийлүүлсэн ч Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд мэдээллийг байршуулахад гэрээний хугацаа хүчин төгөлдөр байх шаардлагын үндсэн дээр гэрээг сунгасан байна.

Эрх шилжиж бүрэн хэрэгжсэн 2 төсөл, арга хэмжээнээс соёлын төвийн тоног төхөөрөмжийг ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.8.29²²-д заасны дагуу гэрээг дүгнээгүй байна.

Хутаг-Өндөр сумын төвийн хатуу хучилттай авто зам барих төсөл, арга хэмжээний гэрээгээр тайлант оны 07 дугаар сарын 01-нд хүлээлгэж өгөхөөр заасан ч ашиглалтад оруулах улсын комиссын 2024 оны 07 дугаар сарын 05-ны А/59 дугаар хурлын тэмдэглэлээр үүрэг даалгавартайгаар хүлээж авчээ. Үүрэг даалгаврын биелэлт, биелэлтийн хяналтыг цаасаар баримтжуулаагүй байна.

3.3 Эрх шилжиж бүрэн хэрэгжсэн зарим хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг техникийн тодорхойлолтын дагуу хүлээж аваагүй байна.

Эрх шилжин ирсэн соёлын төвийн тоног төхөөрөмжийг Дашинчилэн сумын Соёлын төвийн эрхлэгчийн 2024 оны 07 дугаар сарын 30-ны А/18 тушаалаар 4 хүний бүрэлдэхүүнтэй комисс ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн

²¹ авто замын төсөл, арга хэмжээний хувьд Авто замын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу авто замын барилга, засвар, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийн ажлын төсөвт өртөгийн 0.4 хувиас хэтрэхгүй байхаар тооцож гэрээнд тусгах,

²² Төсөл, арга хэмжээний эцсийн буюу бүрэн санхүүжилтийн хүсэлтэд гэрээг дүгнэсэн байх бөгөөд энэ журмын 16 дугаар хавсралтад заасан “Гэрээ дүгнэх маягт”-ыг үйлдэж баримт бичгийн иж бүрдэлд эх хувиар хавсаргаж ирүүлнэ;

хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 15 дугаар хавсралтаар хүлээж аваагүй, техникийн тодорхойлолтоор тулгаагүй байна. Тухайлбал:

Хүснэгт 5: Соёлын төвийн зарим тоног төхөөрөмж

/сая.төгрөгөөр/

№	Тоног төхөөрөмж, техник хэрэгслийн нэр	Нийт дүн	Техникийн тодорхойлолт	Гүйцэтгэлээр
1	Мэргэжлийн дугаралттай хос микрофон /Тайзны мэргэжлийн аудио сет/	19.00	Хөлтэй	Хөлгүй, ашиглахад хүчин чадал муу
2	Найман нүдтэй гэрэл	1.10	Алсын удирдлагатай	Удирдлагагүй
3	Мэргэжлийн тайзны гэрэл	5.10	Доод суурь дугуйтай	Дугуйгүй
4	Шоу мэргэжлийн тайзны гэрэл	3.04	Алсын удирдлагатай	Удирдлагагүй

Эх сурвалж : Дашинчилэн сумын Соёлын төвийн тоног төхөөрөмжийн баримт, материалаас

Эрх шилжин ирсэн Хутаг-Өндөр сумын төвийн хатуу хучилттай авто замыг хууль, журмын дагуу хүлээн авчээ.

Эрх шилжиж ирээгүй ч Булган аймагт хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон тоног төхөөрөмжийг техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгээгүй мөн зарим тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолтыг харьцуулах үзүүлэлтэд дүн шинжилгээ хийх боломжгүйгээр баталсан байна. Тухайлбал:

- Соёлын төвийн тоног төхөөрөмж /Булган/" төсөл, арга хэмжээний дэлгэцийн инч, багтаамж, санах ой,
- Эрүүл мэндийн байгууллагуудын тоног төхөөрөмж /Булган/ төсөл, арга хэмжээний Багц-5 овор хэмжээ, даац техникийн тодорхойлолтод нийцэхгүйгээс гадна баталгаат хугацааны талаах мэдээлэл байхгүйгээс баталгаат хугацаанд эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд засуулах, солиулах арга хэмжээг авч чадахгүйгээс төсвийг үр ашиггүй зарцуулах эрсдэл үүсэж болзошгүй байна.

3.4 Эрх шилжиж ирэн хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг байнгын ашиглагч байгууллага бүртгэлд тусгасан байна.

Эрх шилжиж бүрэн хэрэгжсэн 2 төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг байнгын ашиглагч байгууллагууд 2024 онд бүртгэл тайланд тусгажээ.

Эрх шилжиж ирээгүй Булган аймагт хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон зарим хөрөнгийг байнгын ашиглагч байгууллага огт бүртгээгүй, хугацааны хувьд өмнө болон дараа онд бүртгэсэн, нэг хөрөнгийг хоёр байгууллага давхар бүртгэсэн байна. Тухайлбал:

- Соёлын төвийн тоног төхөөрөмж /Булган, Бугат сум/" төсөл арга хэмжээнээс 13.6 сая төгрөгийн суурин болон зөөврийн компьютерыг 2025 оны 01 дүгээр сард орлого авч бүртгэсэн,
- Соёлын салбарын тоног төхөөрөмж /Булган/" төсөл, арга хэмжээнээс нийт 15.8 сая төгрөгийн хөрөнгийг байнгын ашиглагч байгууллагууд бүртгэлд тусгаагүй,
- Эрүүл мэндийн байгууллагуудын тоног төхөөрөмж /Булган/ төсөл, арга хэмжээнээс 46.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг 2024 оны санхүүгийн тайланд 11, 12 дугаар сард орлого авч бүртгэсэн боловч тухайн хөрөнгө

байнгын ашиглагч байгууллагад бодитоор 2025 оны 04 дүгээр сард хүлээлгэн өгсөн,

- ✚ Хөдөө аж ахуйн салбар болон "Хүлэмж-Хүнс" төслийн тоног төхөөрөмж /Булган/" төсөл, арга хэмжээний 2,474.0 сая төгрөгийн 1000 ш хүлэмжийг аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн XXV/09 тогтоолоор "Хөдөө аж ахуй-хөгжлийн ирээдүй" ОНӨХХК орлого авсан ч ХХААГ-т ХХААХҮС-ын А/437 дугаар тушаалаар давхар орлого авч санхүүгийн тайланд бүртгэсэн

зэрэг зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2²³, ТБОНӨХБАҮХАТ хуулийн 6.2²⁴ заалтуудтай нийцээгүй байна.

Байнгын ашиглагч байгууллагын бүртгэлд тусгагдаагүй зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлага хүргүүлээ.

Төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон зарим хөрөнгийг /Соёлын төвийн тоног төхөөрөмж, ЭМГ, нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн төвийн Мотоцикл, "Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй" ОНӨХХК-ний хүлэмж/ өнөөг хүртэл ашиглаагүй, агуулахад хадгалаастай байгаа нь ашиглагч байгууллагын бодит хэрэгцээ, шаардлага, саналыг дутуу авснаас шалтгаалсан байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд ТЭЗ-аас санал хүргүүлэхдээ төсөвлөлтийн шаардлага хангаагүй буюу улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулаагүй, зарим төсөл арга хэмжээний зураг, төсөв ТЭЗҮ-гүй, аргачлалын дагуу эрэмбэлээгүй, төрийн хэмнэлтийн хуулийн холбогдох заалттай нийцээгүй төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.
2. Эрх шилжин ирсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль журамд нийцүүлэн худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.
3. Эрх шилжин хэрэгжсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн санхүүжилт олгохдоо ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.3-т заасан баримт бичгийн бүрдлийг цаасаар бүрэн бүрдүүлээгүй байна.
4. Эрх шилжин хэрэгжсэн зарим төсөл, арга хэмжээг техникийн тодорхойлолтын дагуу хүлээж аваагүй байна.
5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл арга хэмжээнд захиалагчийн буюу байнгын ашиглагчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн хөрөнгө оруулалтыг төлөвлөж хэрэгжүүлээгүйгээс зарим хөрөнгийг одоог хүртэл ашиглахгүй, агуулахад хадгалаастай байна.

²³ Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага,

²⁴ Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна

6. Хэрэгжиж дууссан төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон 15.8 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд бүртгээгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна.

Аймгийн Засаг дарга Д.Пүрэв-Очир танаа:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө хууль эрх зүйн холбогдох шаардлагад нийцүүлэн төлөвлөх, төлөвлөлтөд тавих хяналтыг сайжруулах
2. Эрх шилжин ирсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолтыг холбогдох хуулийн заалттай нийцүүлэн төлөвлөж хяналтыг сайжруулах.
3. Эрх шилжин хэрэгжсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн санхүүжилт олгохдоо ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.3-т заасан баримт бичгийн бүрдлийг цаасаар бүрэн бүрдүүлэх.

-oOo-

Хавсралт-1

ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ СУДАЛГАА

/сая.төгрөгөөр/

№	ТЕЗ	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөл, арга хэмжээний ангилал /Барилга байгууламж, Их засвар, ТЭЗҮ, Тоног төхөөрөмж/	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Зураг төсөв	ТЭЗҮ	Тайлбар
				Эхлэх	Дуусах					
1	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	Гадна инженерийн шугам сүлжээ /Булган, Дашинчилэн сум/	Барилга байгууламж	2024	2026	2,680.8	500.0	Тийм		
2	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	Хүүхдийн тоглоомын талбай /Булган, Дашинчилэн, Хангал, Хутаг-Өндөр, Бугат, Баян-Агт, Булган сум/	Тоног төхөөрөмж	2024	2026	1,700.0	400.0	Тийм	үгүй	
3	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	Дотуур байрны барилга, 150 ор /Булган, Хангал сум, Хялганат тосгон/	Барилга байгууламж	2024	2025	3,343.3	1,671.7	үгүй		
4	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	Сургуулийн барилга, 320 суудал /Булган, Баян-Агт сум/	Барилга байгууламж	2024	2026	6,947.0	2,084.1	тийм		
5	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	Сургуулийн барилга, 320 суудал /Булган, Сайхан сум/	Барилга байгууламж	2024	2026	5,078.8	1,523.6	тийм		
6	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	Сургуулийн барилгын өргөтгөл, 120 суудал /Булган, Баяннуур сум/	Барилга байгууламж	2024	2025	1,700.0	800.0	үгүй		
7	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	Тусгай хэрэгцээт хүүхдийн яслийн барилга, 60 ор /Булган, Булган сум/	Барилга байгууламж	2024	2025	2,904.7	1,452.4	тийм		
8	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	Цэцэрлэгийн барилгыг буулгаж, шинээр барих, 150 ор /Булган, Булган сум, 6 дугаар цэцэрлэг/	Барилга байгууламж	2024	2025	3,724.4	1,862.2	тийм		
9	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 75 ор /Булган, Рашаант сум/	Барилга байгууламж	2024	2025	2,433.2	1,216.6	тийм		
10	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Булган/	Тоног төхөөрөмж	2024	2024	700.0	700.0		үгүй	
11	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд	Соёлын төвийн барилга, 240 суудал /Булган, Бүрэгхангай сум/	Барилга байгууламж	2024	2026	3,831.9	1,149.6	тийм		
12	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд	Төв номын сангийн барилга /Булган, Булган сум/	Барилга байгууламж	2024	2025	3,130.2	1,565.1	тийм		
13	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд	Соёлын салбарын тоног төхөөрөмж /Булган/	Тоног төхөөрөмж	2024	2024	153.0	153.0		үгүй	

УЛСЫН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

14	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд	Соёлын төвийн тоног төхөөрөмж /Булган, Бугат сум/	Тоног төхөөрөмж	2024	2024	300.0	300.0	үгүй	үгүй
15	Зам, тээврийн сайд	Булган-Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг сум чиглэлийн хатуу хучилттай авто зам /Булган/	Барилга байгууламж	2024	2025	13,374.1	6,687.1		Сэлэнгэ сумын зүүн бүрэн сумын хатуу хучилттай замын зураг төсөв байна
16	Зам, тээврийн сайд	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 1.5 км /Булган, Гурванбулаг сум/	Барилга байгууламж	2024	2025	1,500.0	750.0		
17	Зам, тээврийн сайд	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 1.7 км /Булган, Сайхан сум/	Барилга байгууламж	2024	2026	1,500.0	450.0	тийм	
18	Зам, тээврийн сайд	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 1.7 км /Булган, Сэлэнгэ сум/	Барилга байгууламж	2024	2026	2,200.0	660.0		Баянхонгор сумын галуут баг
19	Зам, тээврийн сайд	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 4.2 км /Булган, Хишиг-Өндөр сум/	Барилга байгууламж	2024	2026	5,322.1	1,596.6	тийм	
20	Зам, тээврийн сайд	Сумын төвийн хатуу хучилттай авто замын эхлэл, 0.8 км /Булган, Хутаг-Өндөр сум/	Барилга байгууламж	2024	2024	600.0	600.0	Үгүй	
21	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Булган/	Тоног төхөөрөмж	2024	2025	2,100.0	1,600.0		Үгүй
22	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	Хөдөө аж ахуйн салбар болон "Хүлэмж-Хүнс" төслийн тоног төхөөрөмж /Булган/	Тоног төхөөрөмж	2024	2024	2,500.0	2,500.0		Үгүй
23	Эрчим хүчний сайд	Сумын цахилгаан хангамж /Булган, Могод сум/	Барилга байгууламж	2024	2024	707.3	707.3	тийм	
24	Эрүүл мэндийн сайд	Эрүүл мэндийн байгууллагуудын тоног төхөөрөмж /Булган/	Тоног төхөөрөмж	2024	2024	700.0	700.0		Үгүй
25	Улсын ерөнхий прокурор	Прокурорын газрын барилга /Булган, Булган сум/	Барилга байгууламж	2024	2026	3,941.8	500.0	үгүй	
Нийт						73,072.6	32,129.3		

-oOo-



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ**

2025 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/07

Булган сум

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 3.1, Монгол Улсын Ерөнхий аудиторын “Эрх шилжүүлэх тухай” 2023 оны А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг УАГ-н Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар, аймгийн Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлж үр дүнг 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хариу ирүүлэхийг аймгийн Засаг дарга (Д.Пүрэв-Очир)-д зөвлөсүгэй.

4. Аудитын зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж хяналт тавьж, дүнг тооцож 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор танилцуулахыг ахлах аудитор (Г.Намчинсүрэн)-д үүрэг болгосугай.

5. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон Булган аймаг дахь Төрийн аудитын архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (Г.Намчинсүрэн), аудитор (А.Сувдаа) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН
ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Ж.ЭНХЦООДОЛ

632501012